



МОНГОЛ УЛС  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

2017 он 01 дугаар  
сарын 23 ны өдөр

Дугаар .ХЭГ/416

Улаанбаатар-12  
Утас: 260817  
Факс: 976-11-310011

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН  
Д.САРАНГЭРЭЛ ТАНАА

Асуулгын хариу хүргүүлэх тухай

Цэвэр агаар сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ажлын үр дүн, Цэвэр агаар сангийн хөрөнгийг хууль бусаар захиран зарцуулсан үйлдэлд хариуцлага тооцсон байдал, агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр Засгийн газраас авч хэрэгжүүлж байгаа болон цаашид хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа арга хэмжээний талаар Монгол Улсын Ерөнхий сайдад тавьсан Таны асуулгын хариуг холбогдох байгууллагаар бэлтгүүлэн үүгээр хүргүүлж байна.

Монгол Улсын сайд,  
Засгийн газрын Хэрэг  
эрхлэх газрын дарга



Ж.МӨНХБАТ

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН Д.САРАНГЭРЭЛЭЭС ЕРӨНХИЙ САЙД  
Ж.ЭРДЭНЭБАТАД ХАНДАЖ ТАВЬСАН АСУУЛГЫН ХАРИУ

**Нэг. Нийслэлийн агаарын бохирдлын талаар**

Сүүлийн 10 гаруй жилийн хугацаанд өвлийн улиралд нийслэлийн агаарын бохирдлын үзүүлэлт зохих хэмжээнээс хэтэрч, агаарын чанарын хувьд аюултай түвшинд хүрэх болсон. Үүний улмаас хүн амын эрүүл мэндэд ихээхэн хор хохирол, сөрөг нөлөөлөл үзүүлж байгаа нь олон улсын болон үндэсний эрүүл мэндийн байгууллага, судлаачдын хийсэн судалгааны үр дүнгээс харагддаг.

2008 оноос хойш байгаль орчны мэргэжлийн байгууллага, судлаачдын хийсэн судалгаа, шинжилгээний үр дүнгээр агаарын бохирдолт нь олон төрлийн үүсгэгчээс үүсч байна. Тухайлбал, Дэлхийн банкнаас эрхлэн 2009-2011 онуудад хийсэн Улаанбаатар хотын агаарын бохирдолтын талаарх судалгаанд нийслэлийн агаарын бохирдлын үүсгэгчдийг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

- гэр хорооллын 190,0 гаруй мянган өрхийн мод, нүүрсээр галлаж байгаа ердийн галлагаатай зуухнаас ялгарч байгаа утаа, үнс тортог;

- нийслэлд бүртгэгдсэн, автозамын хөдөлгөөнд өдөр тутамд оролцож байгаа 400,0 гаруй мянган автомашин, үүний дотор олон жилийн эдэлгээтэй 100,0 орчим мянган хуучин автомашинуудаас ялгарч байгаа утаа болон хорт бодисууд;

- үйл ажиллагаа явуулж байгаа дулааны цахилгаан станцууд болон алслагдсан дүүргийн 3,0 мянга гаруй уурын зуухны галлагаанаас ялгарч байгаа утаа, үнс тортог;

- нийслэлийн нутаг дэвсгэрт ашиглагдаж байгаа хатуу хучилтгүй, ердийн хөрсөн замаас үүсч байгаа тоосжилт;

- гэр хорооллын хог хаягдлын ил задгай овоолго.

Нийслэлийн агаарын бохирдлын томоохон хүчин зүйл болж байгаа халаалтын зуухны талаарх зарим тоо мэдээлэл байдаг.

**10 кВт хүртэлх хүчин чадалтай зуух:**

Монгол Улсын нийт хүн амын 40 гаруй хувь нь Улаанбаатар хотод оршин сууж байгаагаас 2015 оны статистик дүнгээр нийслэлийн төвийн 6 дүүргийн гэр хороололд нийт 198 мянга гаруй өрх бүртгэгдсэнээс ердийн галлагаатай халаалтын эх үүсвэртэй 187 мянган өрх, нам даралтын зуухтай 9,0 мянга гаруй халаалтын уурын зуух бүхий аж ахуйн нэгж, байгууллага үйл ажиллагаа явуулж байна.

Агаарын бохирдлын эх үүсвэрийн улсын 2015 оны нэгдсэн тоо, бүртгэлийн дүнгээр нийслэлийн төвийн 6 дүүрэгт (10 кВт хүртэл хүчин чадалтай) 160,9 мянган зуух бүртгэгдсэний 38 хувь буюу 61,0 мянган өрх нь энгийн зуух, 62 хувь буюу 99,9 мянган өрх нь сайжруулсан зуух ашиглаж байна.

Нийслэлийн Багануур, Багахангай, Налайх дүүрэгт 10 кВт хүртэлх хүчин чадалтай ердийн галлагаатай 9,6 мянган зуух, сайжруулсан 1200 зуух бүртгэгдэж, нийт 10,8 мянган зуух тоологдсон байна. Аймгийн төвүүдэд 10 кВт хүртэлх хүчин чадалтай нийт 114,2 мянган зуух тоологдсоноос ердийн галлагаатай уламжлалт зуух 93 хувь, сайжруулсан зуух 7 хувь байна.

#### **11-100 кВт хүртэлх хүчин чадалтай зуух:**

Нийслэлийн төвийн 6 дүүрэгт 11-100 кВт хүртэл хүчин чадалтай 2,8 мянган усан халаалтын зуух бүртгэгдсэн ба дүүргээр нь авч үзвэл хамгийн их нь Баянзүрх дүүрэгт **698**, Сонгинохайрхан дүүрэгт **675**, Чингэлтэй дүүрэгт **505** зуух ашиглагдаж байгаа бол бусад 3 дүүрэгт 354-395 зуух байна. Багануур, Багахангай, Налайх дүүрэгт 10 кВт хүртэл хүчин чадалтай ердийн галлагаатай 9,6 мянган зуух, сайжруулсан 1,2 мянган зуух, нийт 10,8 мянган зуух тоологдсон байна.

Аймгийн төвүүдэд 11-100 кВт хүртэл хүчин чадалтай зуух нийт 3,4 мянга тоологдсоноос Эрдэнэт, Даланзадгад, Өлгий, Мөрөн, Цэцэрлэг, Арвайхээр сумуудад хамгийн их байна.

#### **101 кВт-аас дээш хүчин чадалтай зуух /нам даралтын зуух /:**

2015 онд Улаанбаатар хотын төвийн 6 дүүрэгт 101 кВт-аас дээш хүчин чадалтай уурын болон усан халаалтын зуух ашиглаж байгаа 158 аж ахуйн нэгж, байгууллагын 319 халаалтын зуух бүртгэгдсэн байна.

Нийслэлд халаалтын улиралд ажилладаг 101 кВт-аас дээш хүчин чадалтай усан халаалтын зуухнуудын 67 орчим хувь нь хаягдал утааны тоос, үнс баригч төхөөрөмжтэй байна. 100 кВт-аас дээш хүчин чадалтай халаалтын зуухнуудад шалгалт хийж утааны хийн хэмжилт, хяналтыг жил бүр хийж байна.

Орон нутагт 101 кВт-аас дээш хүчин чадалтай зуух нийт 72 тоологдсоноос Сайншанд, Ховд, Чойбалсан, Зуунмод, Өлгий, Даланзадгад сумуудад хамгийн олон тооны зуух бүртгэгджээ.

#### **Дулааны цахилгаан станц зэрэг томоохон эх үүсвэрүүд:**

Нийслэлийн хэмжээнд шатааж байгаа нийт нүүрсний 90 орчим хувь буюу жилдээ 4.8 сая гаруй тонн түүхий нүүрсийг дулааны цахилгаан станцууд хэрэглэдэг. Нийслэлд үйл ажиллагаа явуулж байгаа 2, 3, 4 дүгээр Дулааны цахилгаан станц, Амгалан дулааны станцад ажиллаж байгаа нийт 29 зуухны хэрэгцээнд жилдээ 4,8 сая тонн нүүрс, орон нутагт ажиллаж байгаа нийт 72 халаалтын зуухны хэрэгцээнд жилдээ 1,9 сая тонн түүхий нүүрс түлж байна.

#### **Автотээврийн хэрэгсэл:**

Улаанбаатар хотод 2015 онд нийт 439,1 мянган тээврийн хэрэгсэл тоологдож өмнөх жилийнхээс 17 мянган автомашинаар нэмэгдсэн байна. Нийт автомашины 50 хувь нь 15-аас дээш жилийн насжилттай хуучин автомашин байгаа бол 10 орчим хувь нь 6 хүртэл жил ашиглаж байгаа шинэ ба шинэвтэр автомашин байна.

Орон нутагт 2015 онд нийт 281,1 мянган тээврийн хэрэгсэл тоологдож өмнөх жилийнхээс 16 мянган автомашинаар нэмэгджээ.

2015 онд өмнөх онуудын адил суудлын автомашин зонхилон өссөн бөгөөд нийт импортлогдсон автомашины 50 орчим хувийг 15-аас дээш жилийн насжилттай автомашин эзэлж байгаа нь агаарын бохирдлыг нэмэгдүүлэх нэгэн сөрөг нөлөөлөл болж байна.

### **Хоёр. Засгийн газраас авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар**

#### **Цэвэр агаарын сан:**

2015-2016 оны хооронд 47.8 сая долларыг 6 донор байгууллагууд болох Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, ЖАЙКА, Мянганы сорилтын сангаас агаарын бохирдлыг бууруулахад зарцуулсны үр дүнд Улаанбаатар хотын агаарын чанар тэр дундаа PM<sub>2.5</sub> тоосонцорын хэмжээ буурсан үзүүлэлттэй гарсан. Үүнд:

- Мянганы сорилтын сангийн Цэвэр агаар төсөл, Цэвэр агаарын сан, Дэлхийн банкны Улаанбаатар Цэвэр агаар төслийн дэмжлэгтэйгээр 2011-2014 оны хооронд нийт 158,659 ширхэг сайжруулсан зуухыг хөнгөлөлттэй үнээр нийлүүлж 68,0 тэрбум;

- 20,7 мянган ширхэг гэрийн эсгий дулаалга, 5.1 мянган ширхэг гэрийн үүдний гонх, 98 ширхэг эрчим хүчний хэмнэлттэй сууц олгож, нийт 12 тэрбум төгрөг;

- цахилгаанаар халаалтаа бүрэн шийдсэн айл өрхүүд 18 цагаас 19 цагийн хооронд 3000 кВт.ц хүртлэх сайжруулсан зуух хэрэглэж байгаа буюу бусад нөхцөл шалгуурыг хангасан бол сарын нийт 200 кВт.ц хүртлэх хэрэглээг тус тус 50% хөнгөлж, нийт 3,5 тэрбум төгрөг;

- 100 кВт-аас дээш чадалтай 204 нам даралтын зуухыг шинэчилж 12,5 тэрбум төгрөг;

- 100 кВт-аас доош чадалтай 1115 зуухыг төвлөрсөн дулаанд холбож 5,4 тэрбум төгрөг;

- 250 автобусыг хий-дизель хосолмол болгоход 3,3 тэрбум төгрөг;

- “Их тойрог ЦДАШ, дэд станц” төсөлд 52,0 тэрбум төгрөг, “Дулааны цахилгаан станц-4” ТӨХК-ний уур, усны дулаан солилцуулагч бүхий 210 МВт дулааны дэд станц байгуулахад 10,0 тэрбум төгрөг;

- “Дулааны цахилгаан станц-2” ТӨХК-ийг түшиглэн 210 мянган тонн хагас коксжсон түлш үйлдвэрлэх хүчин чадалтай цогцолбор байгуулахад 17,0 тэрбум.

#### **Сайжруулсан зуухны талаар:**

2011-2016 онуудад олон улсын хамтын ажиллагааны төслүүдийн дэмжлэгээр болон Цэвэр агаарын сангийн татаастай үнээр 168,1 мянга, улсын төсвийн хөрөнгөөр 7500 зуух, нийт 175,6 мянган сайжруулсан зуух тараасан нь нийслэлийн гэр хорооллын нийт өрхийн 97,6%-ийг хамарчээ.

Сайжруулсан зуух төслийг хэрэгжүүлснээр дараах үр дүн гарсан байдаг. Үүнд:

- Улаанбаатар хотын хэмжээнд гадаад орчны агаар дахь зуухнаас ялгарч байгаа жижиг ширхэглэлт тоосонцор болох  $PM_{2.5}$ -ийг 30%-аар буюу  $45 \text{ мкг/м}^3$  хүртэл хэмжээгээр бууруулсан.

- Төслийн зуухтай өрхүүд галлагааны зааврыг дагаж мөрдсөнөөр өвлийн улирлын хоногийн нүүрсний хэрэглээг 17%-аар бууруулсан.

- Шөнийн турш өрөөний дундаж температур төслийн зуухтай өрхүүдэд  $1.84^\circ\text{C}$ -ээр илүү байсан.

#### **Сайжруулсан түлшний талаар:**

Нийслэлийн гэр хорооллын түүхий нүүрсний жилийн хэрэглээ ойролцоогоор 480 мянга орчим тонн гэсэн судалгааны дүн гарсан. Сайжруулсан түлш хэрэглэснээр өрхийн түлшний хэрэглээ 3 тонн болж буурах бөгөөд гэр хорооллын нийт өрхийн өвлийн улирлын түлшний хэрэгцээг хангахад 360,0 мянган тонн сайжруулсан түлш шаардахаар байна.

#### **Агаарын чанарыг сайжруулах чиглэлээр 2015-2016 онуудад Засгийн газраас авч хэрэгжүүлсэн зарим арга хэмжээ:**

Цэвэр агаар сангаас агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээнд зориулан 2015 онд нийт 5 тэрбум 257.9 сая төгрөг зарцуулсан. Үүнд:

1. Нийслэлийн гэр хорооллын айл өрхөд сайжруулсан 9459 зуух нийлүүлэхэд зориулан 1,8 тэрбум төгрөгийн татаас олгосон.

2. Чингэлтэй дүүргийн 10 дугаар хорооны захиргаа, өрхийн эмнэлэг, 39 дүгээр сургууль, 124 дүгээр цэцэрлэгийн халаалтын уурын зуухнуудыг буулгаж, төвлөрсөн халаалт, цэвэр, бохир усны шугам сүлжээнд холбосон.

3. Чингэлтэй дүүргийн 9 дүгээр хорооны 31 дүгээр цэцэрлэг, Хан-Уул дүүргийн 7 дугаар сургууль, Баянзүрх дүүргийн Амгалан цогцолборын инженерийн шугам сүлжээг шинэчилж сольсон.

4. Гэр хорооллын цахилгаан эрчим хүчний хангамжийг сайжруулах чиглэлээр Сонгино хайрхан, Чингэлтэй дүүргийн 110/35/10кВт-ын "Телевиз", "Баянгол", "7 дугаар хороолол" дэд станцын шинэ гаргалгаа гаргах, фидерийн ачаалал хөнгөлөх угсралтын ажил гүйцэтгэсэн.

5. Хийн хангамжийн хэрэглээг нэмэгдүүлэх хүрээнд Хилийн цэргийн 0151 дүгээр ангийн халаалтын зуухыг нүүрсний хийгээр хангах шугам сүлжээ барих, туршилт тохируулгын ажил гүйцэтгэсэн.

Агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр Засгийн газраас 2016 онд дараах арга хэмжээг авч хэрэгжүүллээ. Үүнд:

1. Цэвэр агаар сангаас шилжин ирсэн 11 аж ахуйн нэгжийн 2,1 тэрбум төгрөгийн өглөгийг агаарын бохирдлыг бууруулах хөтөлбөрийн бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөрийн зардлаас барагдуулсан.

2. Баянгол дүүргийн агаарын чанарыг сайжруулах бүсэд авч хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд Хөх чоно, Хур туг, Шарын гол, Тара, Үртсэн шахмал

түлшний үйлдвэр зэрэг аж ахуйн нэгжтэй гэрээ хийж, тус дүүргийн 14 түлш борлуулах цэгүүдээр дамжуулан 487,2 тонн түлш нийлүүлсэн.

3. Хан-Уул дүүргийн агаарын чанарыг сайжруулах 3 дугаар бүсэд хамрагдах 10 мянган айл өрхийн хэрэглэж байгаа түүхий нүүрсийг "клийн коал" нүүрс цэвэршүүлэгч уусмалаар баяжуулж, Яармаг, Нисэх орчмын 10 мянган айл өрхөд түгээсэн. Ингэснээр яндангаас гарах бохирдуулагч бодисыг 50-70% бууруулна.

4. Гэр хорооллын айл өрхийн цахилгаан хангамжийн найдвартай ажиллагааг дээшлүүлэх чиглэлээр их тойруугийн зарим дэд станцуудаас 10 кВт-ын шинэ гаргалга гаргаж, фидерийн ачаалал хөнгөлөх ажлуудыг хийсэн.

5. Улаанбаатар хотын 5 дүүргийн 6000 айл өрхийн найдвартай ажиллагааг хангагдаж, цахилгаанаар халаах нөөц чадлыг бүрдүүлсэн.

6. Агаарын бохирдол ихтэй байгаа цэцэрлэгийн усан халаалтын зуухнуудыг шинэ дэвшилтэт технологид шилжүүлэх ажлын хүрээнд Сүхбаатар дүүргийн 166, 175-р цэцэрлэг, Сонгино хайрхан дүүрэгт 125, 38-р цэцэрлэг, Чингэлтэй дүүргийн 154, 173-р цэцэрлэгүүдийн усан халаалтын зуухыг сольж, шинээр бойлуур суурилуулсан.

7. Гэр хорооллын айл өрхийн шөнийн цагийн цахилгааны тарифыг тэглэх тухай Засгийн газраас 2016 оны 214 дүгээр тогтоол баталж, үүнийг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэхийн тулд хүчдэл уналттай хэсгүүдэд трансформаторуудыг шинэчлэх, хүчин чадлыг нь нэмэгдүүлэх ажлыг ээлж дараалалтай хэрэгжүүлж байна. 2016 оны 12-р сарын 31-ний байдлаар 6-10 кВт-ын 17 трансформаторыг шинэчлэн сайжруулсан, цаашид гэр хорооллын бүсэд ашиглаж байгаа хүчин чадал багатай 42 трансформаторыг шинэчлэхээр төлөвлөн ажиллаж байна.

8. Шөнийн цагийн цахилгааны үнийг тэглэх арга хэмжээг өвлийн улиралд буюу жил бүрийн 12 дугаар сарын 1-ний өдрөөс дараа жилийн 3 дугаар сарын 1-ний өдрийн хооронд хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн.

#### **Гурав. Агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр Засгийн газраас авч хэрэгжүүлэх арга хэмжээий талаар**

Монгол Улсын Ерөнхий сайдын 2016 оны 120 дугаар захирамжаар байгуулсан Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах Үндэсний хороо 2016 оны 11 дүгээр сард хуралдаж цаашид хэрэгжүүлэх зарим арга хэмжээний талаар ажлын төлөвлөгөөг батлан гаргаж, холбогдох сайд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг, даалгавар өгсөн.

Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2017 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн өртгөтгөсөн хуралдаанаар агаарын бохирдлыг бууруулах арга замыг Засгийн газар болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдын хуралд цаашид авч хэрэгжүүлвэл зохих арга хэмжээний талаар зөвлөмж хүргүүлсэн.

Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс Засгийн газарт өгсөн дээрх зөвлөмжийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээд холбогдох асуудлыг судалж, хэрэгжилтийг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсгийг Ерөнхий сайдын 2017 оны 5 дугаар захирамжаар байгуулсан.

Нийслэлийн Засаг дарга 2017 оны 1 дүгээр сарын 9-ний өдөр захирамж гарган Нийслэл хотод агаарын бохирдлыг бууруулах бүсчлэлийг тогтоосон бөгөөд цаашид агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээг эдгээр бүс тус бүрт тохирсон, ялгавартай бодлого, арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллах болно. Мөн Нийслэлийн Засаг даргын "Хязгаарлалтын арга хэмжээ авах тухай" захирамжаар эмнэлэгт эмчлүүлэхээс бусад тохиолдолд хөдөө орон нутгаас нийслэлд шилжин ирэх шилжилт хөдөлгөөнийг 2018 оны 1 дүгээр сарын 1-ний өдрийг хүртэл түр хугацаагаар зогсоохоор шийдвэрлэсэн.

Монгол Улсын Засгийн газраас агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр богино болон дунд хугацаанд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. Үүнд:

1. Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсэд авч хэрэгжүүлэх арга хэмжээ, агаарын бохирдол ихтэй аймгуудын агаарын чанарыг сайжруулах бүсэд авч хэрэгжүүлэх арга хэмжээг боловсруулан гаргах;
2. Аймаг, нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсийг тогтоож, бохирдуулагч эх үүсвэрийн тооллогын цэг, мэдээлэл түгээх самбарын тоог нэмэгдүүлэх;
3. Агаарын бохирдлын төлбөрийг зориулалтын дагуу зарцуулахад шаардлагатай эрх зүйн орчныг боловсронгуй болгох;
4. Автомашины түлш, шатахууны чанарт хяналт, шинжилгээ хийж, Евро-5 жишигт нийцсэн үндэсний хэмжээний стандартын төслийг боловсруулан батлуулж, хэрэгжүүлэх;
5. Авто тээврийн хэрэгслээс авах агаарын бохирдлын төлбөрийг тээврийн хэрэгслийн насжилт, бохирдлын хэмжээтэй уялдуулан ялгавартай тогтоох, үзлэг, оношлогооны чанарыг сайжруулах аргачлалыг боловсруулан гаргаж мөрдүүлэх;
6. Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилтуудын хүрээнд "Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр"-ийг шинэчлэн, боловсруулан батлах;
7. Нийслэлийн нутаг дэвсгэрт 5 дугаар цахилгааны станцыг барих ажлыг эрчимжүүлэх, эрчим хүчний нөөцийг нэмэгдүүлэх чиглэлээр тодорхой санал боловсруулж, хэрэгжүүлэх;
8. Техникийн нөхцөл шаардлага бүрдсэн, галын аюулгүй байдлыг хангасан айл өрхүүд халаалтын улиралд, шөнийн цагаар цахилгаан халаагуур хэрэглэхийг дэмжих, цахилгааны тарифыг тэглэсэн арга хэмжээг үргэлжлүүлэх, гэр хорооллын цахилгаан дамжуулах шугамын хүчин чадлыг сайжруулах арга хэмжээг өргөжүүлэх;
9. Агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр тодорхой төслүүдийг амжилттай хэрэгжүүлж байгаа аж ахуй нэгж, иргэдэд урамшуулал олгох;
10. Нийслэлийн ногоон байгууламжийн эзлэх талбайг нэмэгдүүлэх, дүүрэг, хороо бүрт бага гэлтгүй цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, мод тарихыг урамшуулах арга хэмжээ авах;

11. Агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр Японы ЖАЙКА, Дэлхийн банк, НҮБ-ийн Хөгжлийн хөтөлбөрийн газар болон бусад олон улсын байгууллагууд, түншлэгчидтэй хамтарч ажиллах;

12. Нийслэлийн төвлөрлийг бууруулах арга хэмжээг авах, үйл ажиллагаа явуулж байгаа их, дээд сургуулиудыг өөр байршилд шилжүүлэн байрлуулах арга хэмжээг үе шаттайгаар авах;

13. Орон сууцжуулах бодлогыг үргэлжлүүлж, үүний дотор өртөг багатай, иргэдийн худалдан авах чадварт нийцсэн 50-аас доош метр квадрат талбай бүхий орон сууцыг түлхүү барих, зах зээлд нийлүүлэх бодлогыг хэрэгжүүлэх;

Нийслэлийн агаарын бохирдлыг эрс бууруулж, эрүүл аюулгүй орчинг бүрдүүлэхэд багагүй цаг хугацаа, ихээхэн хүч хөрөнгө, ажлын зөв зохион байгуулалт, хүчин чармайлт шаардагдахаар байгаа тул төр, засгийн зүгээс зөв бодлого гаргаж, тууштай хэрэгжүүлэхийн зэрэгцээ нийслэлд ажиллаж, амьдарч байгаа нийт ард, иргэдийн оролцоо, бусдын эрүүл аюулгүй амьдралыг хангах үүрэг хариуцлагаа ухамсарлаж, иргэн бүр тодорхой хэмжээгээр агаарын бохирдолыг бууруулах талаарх төрийн бодлогыг дэмжсэн хүчин чармайлт гаргах шаардлагатай байна.

Мэдээллийн эхэнд дурдсан агаарын бохирдлыг бий болгож байгаа үндсэн бохирдуулагчдыг бууруулах, арилгах, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх чиглэлээр төр, засгийн бүх төвшинд болон ард иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудтайгаа нягт хамтран ажиллаж чадсанаар бид хүн ардын эрүүл, аюулгүй амьдрах тааламжтай орчинг бүрдүүлж чадна гэж үзэж байна.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР